



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 5/46

Улаанбаатар хот

Д.Оюунтөгсийг үүрэгт ажлаас нь чөлөөлж
зарим ажил үйлчилгээ гүйцэтгэх
гэрээ цуцлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, мөн зүйлийн 8.4 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 38.1.2 дахь заалт, Д.Оюунтөгсийн 2020 оны 08 дугаар сарын 03-ны өдөр гаргасан Ажлаас чөлөөлөгдөх тухай өргөдлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Тус газрын гэрээт ажилтан Дүлзэн овогтой Оюунтөгсийн 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан Зарим ажил үйлчилгээг гүйцэтгэх гэрээг 2020 оны 8 дугаар сарын 03-ний өдрөөр дуусгавар болгож цуцалсугай.

2. Д.Оюунтөгсийн ажлыг зохих журмын дагуу тэмдэглэл үйлдэн 2020 оны 8 дугаар сарын 07-ний өдрийн дотор хүлээлцүүлэхийг Мэдээлэл технологийн мэргэжилтэн Б.Шүр-Эрдэнэ, нягтлан бодогч Э.Оюунцэцэг нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс /С.Ганзориг/-т даалгасугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР



000675